



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЖАРГАЛАНТ СУМЫН 1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын код: ХОА-2021/77/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2021 он

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд
тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 70433061 Цахим хаяг: Х
khovd@audit.gov.mn
Аудитын менежер:
Утас: 70432545 Цахим хаяг:
Тунгалаг бүртгэл Аудит ХХК
Аудитор: Ч.Мөнхцооз
Утас: 99028555
Цахим хаяг: munhuu8555@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3. Аудитын тайлан	13
3.1. Ерөнхий зүйл	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	14
3.4. Материаллаг байдал.....	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	16
3.7. Шилэн дансны мэдээлэл	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9. Аудитын илрүүлэлт	17
Залруулсан алдаа	17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	17
Аудитын зөвлөмж.....	
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	17
4. Менежментийн захидал	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64000 Цамбаларав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433081, Факс: 976-70433081
E-mail: khovd@audit.gov.mn

Аудит. 0225 № 2/139
тншй -ны № -т

ЖАРГАЛАНТ СУМЫН 1ДҮГЭЭР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
У.САРУУЛЗАЯА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Жаргалант сумын 1 дүгээр сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалант сумын 1 дүгээр сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, боловсролын үйлчилгээний чанар үр өгөөжийг дээшлүүлж, хүүхдийн сурч хөгжих ээлтэй орчин бүрдүүлэх зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан агуулсан байна. удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

1020298

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>127,707,433.48</u>	<u>206,677,844.09</u>
33	АВЛАГА	6,844,963.09	15,135,045.59
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,370,763.09	12,135,045.59
335	Бусад авлага	4,474,200.00	3,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	4,474,200.00	3,000,000.00
34	УРЬДЧИЛГАА	8,433,400.00	2,700,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	8,433,400.00	2,700,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	8,433,400.00	2,700,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	112,429,070.39	188,842,798.50
351	Түүхий эд материал	644,454.53	784,454.53
35130	Эм боох материал	644,454.53	784,454.53
354	Хангамжийн материал	111,784,615.86	188,058,343.97
35410	Бичиг хэргийн материал	970,100.00	810,100.00
35420	Аж ахуйн материал	11,351,304.00	29,984,624.00
35430	Сэлбэг хэрэгсэл	99,463,211.86	157,263,619.97
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,632,505,223.01</u>	<u>3,536,913,086.74</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,632,505,223.01	3,536,913,086.74
392	Биет хөрөнгө	3,033,699,223.01	2,938,107,086.74
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,059,280,540.66	3,098,812,520.66
39202	Хуримтлагдсан элэгдэл	(203,316,334.85)	(356,047,024.09)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	377,236,527.29	381,929,904.29
39206	Хуримтлагдсан элэгдэл	(305,763,524.07)	(323,248,106.30)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	158,573,028.00	182,944,653.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(93,968,218.02)	(98,399,028.82)
39217	Ном	41,657,204.00	52,114,168.00
393	Биет бус хөрөнгө	598,806,000.00	598,806,000.00
39301	Програм хангамж	1,204,860.00	1,204,860.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,204,860.00)	(1,204,860.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	598,806,000.00	598,806,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,760,212,656.49</u>	<u>3,743,590,930.83</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>12,970,603.60</u>	<u>1,165,897.60</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	12,970,603.60	1,165,897.60
413	Өглөг	12,970,603.60	1,165,897.60
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	10,036,521.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,932,037.60	1,060,897.60
4136	Бусад өглөг	1,002,045.00	105,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,002,045.00	105,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,747,242,052.89</u>	<u>3,742,425,033.23</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,747,242,052.89	3,742,425,033.23
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,472,498,973.00	1,472,498,973.00
51101	Өмч: - төрийн	1,472,498,973.00	1,472,498,973.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,184,539,653.71	1,180,551,529.05
51210	Өмнөх үеийн үр дүн	1,184,539,653.71	1,185,368,548.71
51220	Тайлант үеийн үр дүн	-	(4,817,019.66)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,090,203,426.18	1,089,374,531.18

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,760,212,656.49</u>	<u>3,743,590,930.83</u>
---	--	-------------------------	-------------------------

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,199,890,856.50	2,700,406,046.02
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	38,184,856.50	152,595,546.02
120	Нийтлэг татварын бус орлого	38,184,856.50	152,595,546.02
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	38,184,856.50	152,595,546.02
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,000,000.00	210,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	34,184,856.50	152,385,546.02
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,161,706,000.00	2,547,810,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,837,392,400.00	2,247,148,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,837,392,400.00	2,247,148,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	34,586,500.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,086,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,500,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	289,727,100.00	300,662,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	289,727,100.00	300,662,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,339,861,289.03	2,705,223,065.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,339,861,289.03	2,705,223,065.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,242,014,489.03	2,588,189,965.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,522,162,960.00	1,864,973,130.00
210101	Үндсэн цалин	1,519,521,788.00	1,861,049,993.00
210102	Нэмэгдэл	2,641,172.00	2,433,137.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	1,490,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	188,428,656.79	233,333,721.50
210201	Тэтгэврийн даатгал	128,139,184.55	159,139,782.70
210202	Тэтгэмжийн даатгал	15,072,368.06	18,553,104.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,057,894.46	14,842,483.77
210204	Ажилгүйдлийн даатгал	3,014,473.60	3,708,940.93
210205	Эрүүл мэндийн даатгал	30,144,736.12	37,089,409.40

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	280,246,700.00	255,081,750.00
210301	Гэрэл, цахилгаан	14,615,900.00	14,516,650.00
210302	Түлш, халаалт	230,129,800.00	198,734,200.00
210303	Цэвэр, бохир ус	35,501,000.00	41,830,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,565,403.00	7,326,703.91
210401	Бичиг хэрэг	2,981,000.00	192,500.00
210402	Тээвэр, шатахуун	33,300.00	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,706,400.00	1,775,300.00
210404	Ном, хэвлэл	401,500.00	333,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	256,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,281,203.00	4,569,103.91
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	42,000.00	-
2105	Нормативт зардал	5,512,860.00	14,209,636.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,272,000.00	10,831,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,240,860.00	3,378,436.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,002,200.00	-
210604	Урсгал засвар	11,002,200.00	-
2107	Томилолт, зочны зардал	918,100.00	-
210702	Дотоод албан томилолт	918,100.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	392,000.00	616,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	392,000.00	616,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	209,785,609.24	212,649,024.27
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,244,280.00	3,253,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,092,620.00	18,872,758.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	186,448,709.24	190,522,366.27
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97,846,800.00	117,033,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	97,846,800.00	50,434,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	97,846,800.00	50,434,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	44,791,300.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	44,791,300.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	21,807,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	21,807,000.00

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(139,970,432.53)	(4,817,019.66)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	13,730,437.95	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	13,730,437.95	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(13,730,437.95)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(153,700,870.48)	(4,817,019.66)

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,165,706,000.00	2,548,020,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,000,000.00	210,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,000,000.00	210,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,000,000.00	210,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,000,000.00	210,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,161,706,000.00	2,547,810,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,837,392,400.00	2,247,148,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,837,392,400.00	2,247,148,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	34,586,500.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,086,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,500,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	289,727,100.00	300,662,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	289,727,100.00	300,662,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,165,706,000.00	2,548,020,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,165,706,000.00	2,548,020,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,065,710,000.00	2,430,582,100.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,517,459,200.00	1,879,773,800.00
210101	Үндсэн цалин	1,096,474,000.00	1,041,153,300.00
210102	Нэмэгдэл	323,547,800.00	688,762,210.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	40,332,090.00
210104	Урамшуулал	97,437,400.00	109,526,200.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	189,682,300.00	234,947,500.00
210201	Тэтгэврийн даатгал	128,984,000.00	166,759,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	15,174,600.00	17,046,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,139,600.00	13,637,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,987,600.00	3,409,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	30,396,500.00	34,094,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	281,133,900.00	278,855,500.00
210301	Гэрэл, цахилгаан	14,615,900.00	19,274,400.00
210302	Түлш, халаалт	230,129,800.00	215,825,200.00
210303	Цэвэр, бохир ус	36,388,200.00	43,755,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,115,500.00	7,130,100.00
210401	Бичиг хэрэг	1,074,900.00	1,311,600.00
210402	Тээвэр, шатахуун	33,300.00	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,731,900.00	1,775,300.00
210404	Ном, хэвлэл	573,500.00	1,206,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	590,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,581,900.00	2,046,100.00
2105	Нормативт зардал	3,121,500.00	12,804,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	360,100.00	9,460,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,761,400.00	3,344,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,593,200.00	-
210604	Урсгал засвар	8,593,200.00	-
2107	Томилолт, зочны зардал	918,100.00	-
210702	Дотоод албан томилолт	918,100.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	392,000.00	767,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	392,000.00	767,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,294,300.00	16,303,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,072,000.00	4,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	48,222,300.00	12,303,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	99,996,000.00	117,438,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	99,996,000.00	50,840,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	99,996,000.00	50,840,100.00

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	44,791,300.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	44,791,300.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	21,807,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	21,807,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,472,498,973.00	1,090,203,426.18	1,184,539,653.71		3,747,242,052.89
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,472,498,973.00	1,090,203,426.18	1,184,539,653.71	-	3,747,242,052.89
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,472,498,973.00	1,090,203,426.18	1,184,539,653.71	-	3,747,242,052.89
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,472,498,973.00	1,090,203,426.18	1,184,539,653.71	-	3,747,242,052.89
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-		828,895.00		828,895.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,472,498,973.00	1,090,203,426.18	1,185,368,548.71	-	3,748,070,947.89
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(828,895.00)	-		(828,895.00)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(4,817,019.66)		(4,817,019.66)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,472,498,973.00	1,089,374,531.18	1,180,551,529.05	-	3,742,425,033.23

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,551,810,500	2,481,422,200
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,551,810,500	2,481,422,200
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,471,907,500	2,430,582,100

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,879,578,400	1,879,773,800
210101	Үндсэн цалин	1,043,107,100	1,041,653,300
210102	Нэмэгдэл	706,164,300	688,762,210
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,780,800	39,832,090
210104	Урамшуулал	109,526,200	109,526,200
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	253,743,200	234,947,500
210201	Тэтгэврийн даатгал	178,559,900	166,759,800
210202	Тэтгэмжийн даатгал	18,795,800	17,046,900
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,036,600	13,637,100
210204	Ажилгүйдлийн даатгал	3,759,200	3,409,600
210205	Эрүүл мэндийн даатгал	37,591,700	34,094,100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	298,169,300	278,855,500
210301	Гэрэл, цахилгаан	19,274,400	21,449,400
210302	Түлш, халаалт	231,642,200	213,650,200
210303	Цэвэр, бохир ус	47,252,700	43,755,900
2104	Хангамж, бараа материалын зардал	7,130,100	7,003,100
210401	Бичиг хэрэг	1,311,600	1,184,600
210402	Тээвэр, шатахуун	200,000	200,000
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,775,300	1,775,300
210404	Ном, хэвлэл	1,206,700	1,206,700
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	590,400	590,400
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,046,100	2,046,100
2105	Нормативт зардал	12,804,500	12,804,500
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,460,100	9,460,100
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,344,400	3,344,400
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,493,200	-
210604	Урсгал засвар	2,493,200	-
2107	Томилолт, зочны зардал	918,100	-
210702	Дотоод албан томилолт	918,100	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	767,000	767,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	767,000	767,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,303,700	16,430,700
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,000,000	4,127,000

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,303,700	12,303,700
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,903,000	50,840,100
2132	Бусад урсгал шилжүүлэг	79,903,000	50,840,100
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	79,903,000	50,840,100
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,551,810,500	2,548,020,500
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,247,148,000	2,247,148,000
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,247,148,000	2,247,148,000
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	300,662,500	300,662,500
132001	Орон нутгийн төсвөөс	300,662,500	300,662,500
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,000,000	210,000
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,000,000	210,000
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	118.00	118.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	93.00	93.00
620003	Үйлчлэх ажилтан	24.00	24.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	118.00	118.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	91.00	91.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	1.00	1.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	26.00	26.00

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	8,824,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	8,824,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	8,824,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8,824,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8,824,800.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	8,824,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	8,824,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	150,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	8,674,800.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Жаргалант сумын 1 дүгээр сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг сургуулийн захирал У.Саруулзаяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримтын бүрдүүлэлт, эд хариуцагчийн тайлангийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 2 дугаар сарын 28-наас 2021 оны 03 дугаар сарын 04–ны хооронд Тунгалаг бүртгэл аудит ХХК-ны ахлах аудитор Ч. Мөнхцооз нар хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

1 дүгээр сургууль нь тайлант жилийн үйл ажиллагааны үндсэн зорилгоо Эрүүл биетэй, эрдэм мэдлэгтэй, эелдэг боловсон, эх орондоо хайртай, бүтээлч сэтгэлгээтэй зөв монгол хүүхэд төлөвшүүлэх гэж тодорхойлоод зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:

1. Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, батлагдсан төсвийн хүрээнд төлбөр тооцоог төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах, төсвийн эрсдлийг бууруулж, төсөл хөтөлбөрийг хамгийн бага зардлаар үр ашигтай санхүүжүүлж, мөнгөн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх
2. Бага боловсролыг түвшинд “Эрүүл чийрэг бие бялдартай, гоо зүй, ёс суртахууны мэдрэмжтэй хүмүүнлэг иргэнийг төлөвшүүлэх”.
3. Дунд боловсролын түвшинд “Сурагчийн нийгэмших, иргэнших талыг нэмэгдүүлэх, байнга өөрчлөгдөж буй нөхцөл байдалд амьдрах арга ухаанд тасралтгүй суралцах чадвартай иргэнийг төлөвшүүлэх”.
4. Ахлах боловсролын түвшинд “Сургалтаар олж авсан шинжлэх ухааны мэдлэг мэдээллийг амьдрал, үйлдвэрлэлд турших, чадвар бүхий оюунлаг ардчилсан нийгмийн хууль ёсийг сахин биелүүлдэг иргэнийг төлөвшүүлэх” гэсэн зорилтуудыг дэвшүүлж хэрэгжүүлэхийн төлөө үйл ажиллагаагаа чиглүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна.

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай
- Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 450 тоот “Хоолны зардлын норматив тогтоох тухай”

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Жаргалант сумын 1 дүгээр сургуулийн удирдлага нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд тус байгууллагын 2018-2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлж 34492,1 төгрөгийн алдаа зөрчил илрүүлж 7243,9 төгрөгийг төлүүлэх акт, 27248,2 төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага өгчээ.

Шилэн дансанд хийсэн дотоод аудитаар зөрчил арилгах арга хэмжээ авагдаагүй байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ бага ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1% хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 2705223,0 мянган төгрөгөөс нэг хувиар тооцон 27052,2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Жаргалант сумын 1 дүгээр сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 36534,8 мянган төгрөгөөр буюу 1,9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материалын болон үндсэн хөрөнгийн дансдуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	6,844,963	15,135,046	8,290,083
Урьдчилгаа	8,433,400	2,700,000	(5,733,400)
Бараа материал	112,429,070	188,842,799	76,413,728
Үндсэн хөрөнгө	3,632,505,223	3,536,913,087	(95,592,136)
Нийт хөрөнгө	3,760,212,656	3,743,590,931	(16,621,726)
Өр төлбөр	12,970,604	1,165,898	(11,804,706)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,747,242,053	3,742,425,033	(4,817,020)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,760,212,656	3,743,590,931	(16,621,726)

Авлага дансны үлдэгдэл 8290,0 мянган төгрөгөөр өссөн нь тооцооллын алдаанаас хамаарч илүү шилжүүлсэн ХАОАТ-н 6112,6, НДШ-н 4502,9, үдийн цайны өмнөх оны авлагын үлдэгдэл 3000,0, ҮЭ-н байгууллагаас авах 1519,5 нийт 8290,0 мянган төгрөгийн авлага нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материал данс 76413,7 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь утаанаас хамгаалах зориулалтаар 14916,0 мянган төгрөгийн үнэ бүхий 132 ширхэг цонхонд агаар шүүгч суулгасан, Мобикомоос хандивласан 3 ширхэг ус цэвэршүүлэгч 2550,0, БСУГ-аас нийлүүлсэн хичээлийн хэрэглэгдэхүүн 1447,0, сэлбэг хэрэгсэл дансанд БСУГ-аас бэлтгэн нийлүүлсэн хими физикийн лабораторийн тоног хэрэгсэл 55776,0 мянган төгрөгийн бараа материал хичээлийн хэрэглэгдэхүүн хүлээн авч данс бүртгэлд тусгасантай холбоотой өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 95592,1 мянган төгрөгөөр буурсанд тайлант жилийн элэгдлийн зардал 190522,3 мянган төгрөг ихээхэн нөлөө үзүүлж байгаа боловч барилгын сантехникийн засвар 29531,9, агуулахын барилга 10000,0 нийт 39531,9 мянган төгрөгийн үнийн дүн бүхий ажил үйлчилгээг Жаргалант сумын ОНХсангаас санхүүжүүлсэн, БСУГ-аас нийлүүлсэн 2 ширхэг компьютер 3586,4, 55 инчийн телевизор 2 ширхэг 3010,4, зөөврийн 3 ширхэг өсгөгч 1938,0, сурагчийн ширээ сандал 34956,5, сурах бичиг, ном 8711,8 нийт 91735,1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого авч данс бүртгэлд тусган тайлагнажээ. Эдгээр хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн нөлөөллөөс үндсэн хөрөнгө данс дүнгээрээ буурсан байна.

Хүснэгт 2 Орлогын үзүүлэлтүүд

Үзүүлэлт	өмнөх оны	тайлант оны	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Улсын төсвөөс олгосон санхүүжилт	1,837,392,400	2,247,148,000	409,755,600
Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт	289,727,100	300,662,500	10,935,400
Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө	34,184,856	152,385,546	118,200,690
түрээсийн орлого	4,000,000	210,000	(3,790,000)
бусад төвлөрүүлэх шилжүүлэг	34,586,500	-	(34,586,500)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,199,890,856	2,700,406,046	500,515,190

Жаргалант сумын 1 дүгээр сургуулийн нийт орлого өмнөх оноос 500515,2 мянган төгрөгөөр буюу 22,7 хувиар өссөн байна. Улсын төсвийн санхүүжилт Засгийн газрын 2019 оны 472 тоот тогтоолоор цалин нэмэгдэх шинэчлэл хийгдсэнтэй хамааралтай өсчээ.

Орон нутгийн төсвийн санхүүжилт 10935,4 мянган төгрөгөөр өссөн нь цахилгаан, цэвэр бохир усны үнийн өсөлттэй холбоотой байна.

Байгууллагын үйл ажиллагааны орлогоос 4000,0 мянган төгрөг орохоор төлөвлөсөн боловч цар тахлын улмаас үйл ажиллагаа хязгаарлагдсанаас гүйцэтгэлээр 210,0 мянган төгрөг оржээ.

Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө, материалын орлого 118200,6 мянган төгрөгөөр өссөн нь дээрх хөрөнгө оруулалт, тусламжийн хүрээнд нэмэгдсэн 91735,1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 60650,4 мянган төгрөгийн хичээлийн хэрэгдэхүүн хүлээн авсантай холбоотой байна.

Хүснэгт 3 зардлын үзүүлэлтүүд

Үзүүлэлт	өмнөх оны	тайлант оны	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Цалин хөлс нэмэгдэл урамшуулал НДШ	1,710,591,617	2,098,306,852	387,715,235
Байр ашиглалттай холбоотой зардал	280,246,700	255,081,750	(25,164,950)
Хангамж бараа материалын зардал	23,565,403	7,326,704	(16,238,699)
нормативт зардал	5,512,860	14,209,636	8,696,776
Бусад бараа үйлчилгээний зардал	319,944,709	263,699,825	(56,244,884)
бусад урсгал шилжүүлэг		66,598,300	66,598,300
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	2,339,861,289	2,705,223,066	365,361,777

Нийт зардал өмнөх оноос 365361,7 мянган төгрөгөөр буюу 15,6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс цалин хөлс, шимтгэлийн зардал 387715,2 өсөж, бусад урсгал зардал 22353,4 мянган төгрөгөөр буурсан материаллаг өөрчлөлт гарчээ. Энэ нь халаалтын хугацаа хойшилсон, усны төлбөрийг хагас сараар хөнгөлсөн, бусад цаг үеийн нөхцөл байдлын улмаас үйл ажиллагаа хязгаарлагдсантай хамааралтай байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1510913,7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1510913,7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 1510913,7 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2551810,5 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 2247148,0 орон нутгийн төсвөөс 300662,5 мянган төгрөгийг, үйл ажиллагааны орлогоос 4000,0 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2247148,0 мянган төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 300662,5 мянган төгрөг, байгууллагын үйл ажиллагааны орлогоос 210,0 мянган төгрөг нийт 2548020,5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2481422,2 мянган төгрөгийг зарцуулж 66598,3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлангийн хугацаанд нэмэлт дансаар 12835.9 мянган төгрөгийн ажил гүйлгээ гарснаас 4011,1 мянган төгрөг нь нийгмийн даатгалын сангаас олгосон лист, 150,0 боловсролын үнэлгээний төвийн урамшуулал, 8674,8 мянган төгрөг нь сурах бичгийн

түрээсийн төлбөр цуглуулан шилжүүлсэн дүн байна. Нэмэлт санхүүжилтийн тайланд НД байгууллагаа олгосон тэтгэмжийг тохируулан цэвэрлэсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд хэрэгжүүлсэн горим сорилын дүнгээр алдаа зөрчил илэрсэнгүй.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өөрийн орлогоос хамаарч төсөв хэтэрсэн зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн нь хэрэгжсэн байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 10491,9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 828,8 мянган төгрөгийн алдааг залруулж, үр дүнгийн урамшууллын хувь хэмжээ зөрүүтэйгээс илүү олгосон 1373,0 мянган төгрөгийг төлүүлэх акт тогтоож, бараа материалын тайлан, тооцоо бодолт, анхан шатны баримт бүрдүүлэлт, авлага үүсгэхгүй ажиллах зэрэг 3 чиглэлийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Эрх бүхий байгууллагын шийдвэрээр акталсан хөрөнгөнд ногдох дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжилтийг бүртгээгүй 828895 төгрөгийн залруулгыг хийлээ.

- Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар илэрсэн 1373.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоов.

Үүнд:

Ажиллагсад үр дүнгийн урамшууллын хувь хэмжээ зөрүүтэйгээс илүү олгосон зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д дансны өглөг авлага, төлбөрийн тооцоог хянах ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах, заалттай нийцэхгүй, үнэн зөв бодитой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: нийт 1373.1 мянган төгрөгийн төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

- Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД:

Хүүхдийн хоолны хэмнэгдсэн зардлаас 800.0 мянган төгрөгийн маскиг Буянт үйлийн шим ХХК-нд нийлүүлсэн зэрэг асуудлыг аймгийн ТЕЗ-ын нэгдсэн тайланд аймгийн хэмжээнд авч үзэх шаардлагатай байна

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Зардлын данстай холбоотой асуудал.

- 1.1. **Илрүүлэлт:** Эд хариуцагчийн тайлан гаргалт хангалтгүй, тооцоог актаар баталгаажуулаагүй
- 1.2. **Эрсдэл:** Төсвийн болон нягтлан бодох бүртгэлийн хууль, тэдгээрийг хэрэгжүүлэх журам дүрэм зөрчигдөх
- 1.3. **Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 5.1.2-д заасан иж бүрэн, үнэн зөв байдлыг хангах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д заасан анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах
- 1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвшөөрч байна.

2.1. **Илрүүлэлт:** Татварын нэгдсэн системд холбогдсон бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжээс хэвлэсэн төлбөрийн баримт дутуу

2.2. Эрсдэл: тайлан буруу илэрхийлэгдэх, хуурамч зарлага гаргах

2.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх зарчмыг баримтлан ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар Зөвшөөрч байна.

Балансын данстай холбоотой асуудал

3.1. **Илрүүлэлт:** ХАОАТ-н 6112,6, НДШ-н 4502,9, үдийн цайны өмнөх оны авлагын үлдэгдэл 3000,0 , ҮЭ-н байгууллагаас авах 1519,5 нийт 8290,0 мянган төгрөгийн авлага нэмэгдсэн, өмнөх авлага буураагүй байна.

3.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах

3.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж **авлага**, өр төлбөр үүсгэхгүй байх заалтыг хэрэгжүүлэн ажиллах

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар Зөвшөөрч байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн/ мян.төг/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Үр дүнгийн урамшууллын хувь хэмжээ зөрүүтэйгээс илүү олгосон	1,373,1	акт	захирал Ня-бо	У.Саруулзаяа П.Амгаланбаатар

2	Эрх бүхий байгууллагын шийдвэрээр акталсан хөрөнгөнд ногдох дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжилтийг бүртгээгүй	828,9	залруулга	захирал Ня-бо	У.Саруулзаяа П.Амгаланбаатар
3	Эд хариуцагчийн тооцоог актаар баталгаажуулаагүй	-	Зөвлөмж	захирал Ня-бо	У.Саруулзаяа П.Амгаланбаатар
4	НӨАТ-н баримт дутуу	-	Зөвлөмж	захирал Ня-бо	У.Саруулзаяа П.Амгаланбаатар
5	ХАОАТ-н 6112,6, НДШ-н 4502,9, үдийн цайны өмнөх оны авлагын үлдэгдэл 3000,0, ҮЭ-н байгууллагаас авах 1519,5 нийт 8290,0 мянган төгрөгийн авлага нэмэгдсэн, өмнөх авлага буураагүй	8290	Зөвлөмж	захирал Ня-бо	У.Саруулзаяа П.Амгаланбаатар
	НИЙТ ДҮН	10491.9			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР